

**“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АГААРААС АВРАХ АНГИД НЭМЭЛТ СУРГАЛТ ЯВУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 20-ны Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин уг төслийн хүрээнд сургалтад зарцуулах төсөв нь нийт санхүүжилтийн 50 гаруй хувьтай тэнцэж байна гээд уг сургалтын төсвийг хэрхэн зарцуулах, сургалтад хамрагдаж, бэлтгэгдсэн нисгэгчид, алба хаагчдыг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах талаар баримтлах бодлогын тухай ажлын хэсгээс тодруулан асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан төслийн хүрээнд авч байгаа зээлийн санхүүжилтийг үр дүнтэй, оновчтой зарцуулахад анхаарах, зарцуулалтыг нь ил тод байлгах шаардлагатай болохыг ажлын хэсэгт анхаарууллаа.


“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.ЭНХ-АМГАЛАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ний ны өдөр

Төрийн өрдөн, Улаанбаатар  
хот

### САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** ~~"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"~~ ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийн Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг